

**Иргэний нисэхийн аюулгүй
байдлын эрх зүйн баримт
бичгүүдийн нэр томъёо,
тодорхойлолтуудын
ЭМХЭТГЭЛ**

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

3.1.1 “**агаарын зам**” гэж агаарын хөлгийн нислэгийг аюулгүйгээр гүйцэтгэхэд зориулагдсан өндөр ба өргөнөөр хязгаарлагдсан агаарын зай;

3.1.2 “**агаарын навигаци**” гэж агаарын хөлгийн байршил, хөдөлгөөнийг тодорхойлох, удирдан чиглүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны цогцолбор;

3.1.3 “**агаарын хаалга**” гэж улсын хилийг агаарын замаар нэвтрэх газар зүйн байрлал;

3.1.4 “**агаарын хөлөг**” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах аливаа төхөөрөмж;

3.1.5 “**агаарын хөлгийн дарга**” гэж агаарын хөлгийн удирдлагыг гүйцэтгэж, нислэгийн аюулгүй ажиллагааг биечлэн хариуцаж байгаа нисэгч;

3.1.6 “**аэродром**” гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулж тусгайлан тоногдсон газар болон усан гадаргуу;

3.1.7 “**аэродром орчмын аюулгүйн бүс**” гэж аэродромыг байгуулахдаа нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зайлшгүй шаардлагыг үндэслэн тогтоосон тодорхой хэмжээний хуурай газар, усан гадаргуу, орон зай;

3.1.8 “**аюултай ачаа**” гэж агаараар тээвэрлэх үед өөрийн шинж чанараараа иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө болон нислэгийн аюулгүй ажиллагаанд үлэмж хор хүргэж болох биет зүйл болон бодис;

3.1.9 “**улсын агаарын хөлөг**” гэж цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын агаарын хөлөг

3.1.10 “**иргэний агаарын хөлөг**” гэж улсын агаарын хөлгөөс бусад бүх төрлийн агаарын хөлөг;

3.1.11 “**Монгол Улсын агаарын зай**” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээшхи хийн мандлын агаарын давхрагын орон зай;

3.1.12 “**нислэг**” гэж агаараас хүнд агаарын хөлгийн хувьд хөөрөх зорилгоор зогсоолоос хөдлөхөөс эхлэн газарт эргэн бууж хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх; агаараас хөнгөн агаарын хөлгийн хувьд газрын гадаргуугаас хөөрөхөөс эхлэн газардах хүртэлх үйл ажиллагаа;

3.113. **“нисэхийн аюулгүй ажиллагаа”** гэж нислэгийн үйл ажиллагаа болон түүнд хамаарах бусад үйл ажиллагааг хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг;

3.114. **“нислэгийн Мах-ын тоо”** гэж агаарын бодит хурдыг дууны хурдад харьцуулсан харьцаа;

3.115. **“нислэгт тэнцэх чадвар”** гэж агаарын хөлөг, түүний эд ангиуд нь тэдгээрт тавих аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэж байгаа байдал;

/Энэ заалтыг 2001 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.116. **“нисэх”** гэж агаарын хөлөг болон түүнд хамаарах бүтээгдэхүүнийг зохион бүтээх, үйлдвэрлэх, тэдгээрээр үйл ажиллагаа эрхлэх цогцолбор ойлголт;

3.117. **“нисэхийн аюулгүй байдал”** гэж нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогцолбор арга хэмжээ;

3.118. **“нисэх буудал”** гэж аэродром, агаарын тээврийн үйлчилгээний барилга, байгууламжийн цогцолбор;

3.119. **“нисэхийн бичиг баримт”** гэж энэ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу нисэхэд хамаарах үйл ажиллагаа (хуулийн этгээд, аэродром, агаарын хөлөг, түүнд хамаарах бүтээгдэхүүн болон тэдгээрийн үйлдвэрлэл, нисэхэд холбоотой бусад үйлчилгээ)-нд иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон гэрчилгээ, үнэмлэх, зөвшөөрөл болон бусад бичиг баримт;

3.120. **“олон улсын нислэг”** гэж хоёр буюу түүнээс дээш улсын агаарын зайд үйлдэх нислэг;

/Энэ заалтыг 2001 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.121. **“шинжлэн шалгах”** гэж гарч болзошгүй нислэг-техникийн хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, түүнчлэн гарсан хэргийн шалтгааныг тогтоон аюулгүй байдлын зөвлөмж бэлтгэх үйл ажиллагаа;

3.122. **“Чикагогийн конвенци”** гэж Монгол Улс 1989 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Чикаго хотноо батлагдсан олон улсын конвенци болон түүний Хавсралтууд гэж тус тус ойлгоно;

3.123. **“агаарын тээвэрлэгч”** гэж агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний үндсэн дээр агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг

3.124. **“агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ”** гэж агаарын хөлгөөр арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхэлж эрх олгож буй тусгай зөвшөөрөл;

3.125. **“нисэх баг”** гэж нислэгийн хугацаанд агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангах хариуцлага хүлээсэн, хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэхтэй агаарын хөлгийн багийн гишүүд;

3.126. **“агаарын хөлгийн зорчигч”** гэж агаарын хөлгөөр зорчихоор агаарын тээвэрлэгчтэй гэрээ байгуулсан этгээд.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ

- 1.5.1. **“агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр”** гэж зорчигч, агаарын хөлгийн багийн гишүүн, газрын үйлчилгээний ажилтан, түүнчлэн агаарын хөлгийг газарт болон агаарт тохиолдож болох хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор энэ журмын шаардлагад нийцүүлэн боловсруулсан агаарын тээвэрлэгч байгууллага, эсхүл түүний төлөөлөгчийн хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон баримт бичгийг;
- 1.5.2. **“агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлс”** гэж агаарын тээвэрлэгчийн дотоод үйл ажиллагаанд зориулагдсан өөрийн, эсхүл гэрээт байгууллагад хүргүүлэх зорилгоор тээвэрлэгдэх бичиг баримт, хангамжийн материал, техник үйлчилгээний сэлбэг, нислэгийн хоол хүнс, цэвэрлэгээний болон бусад зүйлсийг;
- 1.5.3. **“агаарын хөлгийн аюулгүй байдлын үзлэг”** гэж сэжигтэй зүйлс, зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс болон бодисыг илрүүлэх зорилгоор агаарын хөлгийн дотор талд хийх үзлэгийг;
- 1.5.4. **“агаарын хөлгийн аюулгүй байдлын шалгалт”** гэж сэжигтэй зүйлс, зэвсэг, тэсрэх бодис эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс болон бодисыг илрүүлэх зорилгоор агаарын хөлгийн дотор болон гадна талд хийх шалгалтыг;
- 1.5.5. **“анкет шалгалт”** гэж нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх хүсэлт гаргасан этгээдийн биеийн байцаалт болон өмнөх туршлага, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, аюулгүй байдалтай холбоотой бусад мэдээллийг шалгахыг;
- 1.5.6. **“аюулгүй байдал”** гэж хүний болон материаллаг нөөцийг хослуулах замаар иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах арга хэмжээг;
- 1.5.7. **“аюулгүй байдлын аудит”** гэж энэхүү журмын хэрэгжилтэд хийх шалгалтыг;
- 1.5.8. **“аюулгүй байдлын хяналт”** гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис эсхүл аюултай хэрэгсэл, эд зүйлс болон бодисыг агаарын хөлөгт нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг;
- 1.5.9. **“аюулгүй байдлын үзлэг”** гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс болон бодисыг илрүүлэхэд чиглэсэн техникийн болон бусад арга хэрэгслээр хийх үзлэгийг;
- 1.5.10. **“аюулгүй байдлын сорилт”** гэж хөндлөнгийн хууль бус үйлдэл хийх байдлаар нисэхийн аюулгүй байдлын үйл ажиллагааг ил болон далд хэлбэрээр шалгахыг;

- 1.5.11. **“дамжин өнгөрөх зорчигч”** гэж тухайн аяллын завсрын нисэх буудалд ирсэн агаарын хөлгөөрөө нислэгээ цааш үргэлжлүүлэх зорчигчийг;
- 1.5.12. **“дамжин өнгөрөх тээш”** гэж тухайн аяллын завсрын нисэх буудалд ирсэн агаарын хөлгөөс буулгалгүй үргэлжлүүлэн тээвэрлэх тээшийг;
- 1.5.13. **“дипломат тээш болон илгээмж”** гэж 1961 онд Австри Улсын Вена хотноо баталсан Дипломат харилцааны тухай болон 1963 онд баталсан Консулын харилцааны тухай конвенцийн дагуу тээвэрлэх дипломат шуудан болон материалыг;
- 1.5.14. **“нийтийн эзэмшлийн бүс”** гэж ямар нэг зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй нэвтэрч болох нисэх буудлын барилга байгууламж, түүний орчны хэсгийг;
- 1.5.15. **“нислэгийн аюулгүй байдлын ажилтан”** гэж агаарын тээвэрлэгчийн харьяалах улсын Засгийн газраас эрх олгосон болон агаарын хөлгийн бүртгэлтэй улсын Засгийн газраас тухайн агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүсийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахаар томилсон (агаарын хөлөгт нэг буюу хэсэг хүмүүсийг тусгайлан хамгаалахаар томилогдсон хувийн бие хамгаалагч үүнд хамаарахгүй) этгээдийг;
- 1.5.16. **“Нисэх буудлын аюулгүй байдлын хороо”** гэж иргэний нисэхийн болон нисэх буудлын аюулгүй байдлыг хариуцсан албан тушаалтанд зөвлөгөө өгөх хороог;
- 1.5.17. **“нисэхийн аюулгүй байдлын үүрэг хүлээсэн байгууллага”** гэж иргэний нисэхийн аюулгүй байдлын журмыг боловсруулах, өөрчлөх санал гаргах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагыг;
- 1.5.18. **“нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөр”** гэж хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор энэ журмын шаардлагад нийцүүлэн боловсруулж, нисэх буудалд хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон баримт бичгийг;
- 1.5.19. **“нислэгийн үед хэрэглэгдэх эд зүйлс”** гэж нислэгийн үед зорчигчийн үйлчилгээнд хэрэглэх, эсхүл худалдах эд зүйлсийг;
- 1.5.20. **“онцгой анхаарлын цэг”** гэж гэмтсэн болон устгагдсаны улмаас иргэний нисэхийн үйл ажиллагаанд ноцтой саад учруулж болзошгүй нисэх буудлын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг;
- 1.5.21. **“тусгай зориулалтын нислэг”** гэж хөдөө аж ахуй, барилга байгууламж, зураг авах, хайгуул, ажиглалт, эргүүл, эрэн хайх, авран туслах, зар сурталчилгаа зэрэг үйлчилгээ үзүүлэх зорилгоор гүйцэтгэж байгаа нислэгийг;
- 1.5.22. **“тээш ялгах талбай”** гэж тээшийг аяллын дугаар, чиглэлээр нь ялгах талбайг;
- 1.5.23. **“үйлчилгээнд гарсан агаарын хөлөг”** гэж нислэгт бэлэн болж баталгаажсан, аяллын дугаар олгогдсон, зорчигчийг хүлээн авах бэлтгэлийг хангаж, агаарын хөлгийн диспетчерийн хяналтад орсон, зогсоолд байрласан агаарын хөлгийг;

- 1.5.24. **“үзлэгийн дараахь бүс”** гэж аюулгүй байдлын үзлэгийн цэг болон агаарын хөлгийн хоорондох хэсгийг;
- 1.5.25. **“сэжигтэй эд зүйлс”** гэж эзэнгүй, эсхүл эзнийг нь тогтоох боломжгүй, аюул, заналхийлэл агуулсан байж болзошгүй эд зүйлсийг;
- 1.5.26. **“хамгаалагдсан бүс”** гэж аюулгүй байдлын хяналт бүхий нисэх буудлын аэродромын талбай, барилга байгууламж, түүний орчны хэсгийг;
- 1.5.27. **“хориотой бүс”** гэж аюулгүй байдлын үзлэгийн цэгээс агаарын хөлөг хүртэлх зорчигчдын танхим, тээш ялгах талбай, перрон, нислэгт бэлтгэгдсэн агаарын хөлөг, аюулгүй байдлын үзлэг хийгдсэн тээш, ачаа, шуудан болон хамгаалагдсан бүсэд байрлах нислэгийн хоол, хүнс бэлтгэх газар, цэвэрлэгээний талбай зэрэг илүү эрсдэлтэй гэж тодорхойлогдсон, нэвтрэх хяналт, бусад аюулгүй байдлын хяналт илүү шаардлагатай хамгаалагдсан бүсийн хэсгийг;
- 1.5.28. **“хориглосон эд зүйлс”** гэж агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон, эсхүл зөвхөн тусгай журмын дагуу тээвэрлэх хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй эд зүйлсийг;
- 1.5.29. **“хөндлөнгийн хууль бус үйлдэл”** гэж иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлөх дараахь үйлдэл болон оролдлогыг:
1. агаарын хөлгийг хууль бусаар **булаан эзлэх**;
 2. үйлчилгээнд гарсан агаарын хөлгийг устгах;
 3. агаарын хөлөгт болон нисэх буудалд **хүн барьцаалах**;
 4. агаарын хөлөг, нисэх буудлын хамгаалагдсан бүс болон агаарын навигацийн тоног төхөөрөмж, байгууламжид **хүч түрэмгийлэн нэвтрэх**;
 5. гэмт хэрэг үйлдэх зорилгоор агаарын хөлгийн бүхээг, нисэх буудалд **зэвсэг, эсхүл аюултай хэрэгсэл болон эд зүйлсийг нэвтрүүлэх**;
 6. үйлчилгээнд гарсан **агаарын хөлгийг** хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах буюу үхэлд хүргэх, эсхүл эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд **ноцтой хохирол учруулах зорилгоор ашиглах**;
 7. нислэг үйлдэж буй, эсхүл газарт байгаа агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа, нисэх буудал, түүний барилга байгууламж дахь зорчигч, нисэх багийн гишүүд, газрын үйлчилгээний ажилтан болон иргэдийн **аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хуурамч мэдээ, мэдээллийг тараах**.
- 1.5.30. **“нийтийн хэв журам зөрчсөн зорчигч”** гэж нисэх буудал, агаарын хөлгийн бүхээгт хууль тогтоомж зөрчсөн, нисэх буудлын ажилтан, нисэх багийн гишүүдийн зааварчилгааг үл даган нисэх буудал болон агаарын хөлгийн хэвийн ажиллагааг алдагдуулж буй этгээдийг;
- 1.5.31. **“шилжүүлэн ачих ачаа ба шуудан”** гэж тээвэрлэгдэж ирсэн агаарын хөлгөөс өөр агаарын хөлөгт шилжүүлэн ачих ачаа ба шууданг;

- 1.5.32. **“шилжин суух зорчигч”** нэг агаарын хөлгөөс нөгөө агаарын хөлөгт шилжин суух зорчигчийг;
- 1.5.33. **“шуудан”** гэж Дэлхийн шуудан холбооны дүрмийн дагуу шуудангийн байгууллагад хүргэх захидал болон бусад зүйлсийг;
- 1.5.34. **“зохицуулалттай ачаа зуучлалын байгууллага”** гэж Иргэний нисэхийн ерөнхий газраас хүлээн зөвшөөрөгдсөн, агаарын тээвэрлэгчтэй хамтран үйл ажиллагаа явуулдаг, аюулгүй байдлын хяналтыг хангаж ажилладаг хуулийн этгээдийг;
- 1.5.35. **“аюулгүй байдлын үзлэг шалгалт”** гэж эрх бүхий байгууллагаас нисэх буудал, агаарын тээвэрлэгч, иргэний нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага болон бусад байгууллага энэ журамд заасан аюулгүй байдлын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих үйл ажиллагааг;
- 1.5.36. **“үнэмлэхжүүлэлт”** гэж нисэхийн аюулгүй байдлын үүрэг хүлээсэн байгууллагаас тухайн этгээд зохих түвшинд өөрийн үүргийг гүйцэтгэх чадвартайг үнэлж, баталгаажуулах үйл ажиллагааг;
- 1.5.37. **“тогтмол илгээгч”** гэж аюулгүй байдлын нийтлэг дүрэм, шаардлагыг хангасан ачаа, шууданг тээвэрлэгчийн хяналтад шилжүүлж, агаарын хөлгөөр тээвэрлэхийг зөвшөөрсөн этгээдийг;
- 1.5.38. **“өндөр эрсдэлтэй ачаа, шуудан”** гэж тагнан турших үйл ажиллагааны үр дүнд иргэний нисэхийн үйл ажиллагаанд заналхийлэл учруулж болзошгүй гэж үзсэн, сэжиг төрүүлэхүйц, хэвийн бус, эсхүл хөндөгдсөн шинжтэй ачаа, шууданг;
- 1.5.39. **“арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа”** гэж зорчигч, ачаа, тээш, шууданг агаарын хөлгөөр төлбөртэй тээвэрлэх үйл ажиллагааг;
- 1.5.40. **“урьдчилан тааварлах боломжгүй байдал”** гэж аюулгүй байдлыг хангах арга хэмжээний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор хяналт шалгалтыг тогтмол бусаар өөр өөр байршилд, эсхүл өөр арга хэрэгсэл ашиглан хэрэгжүүлэх арга хэмжээг;
- 1.5.41. **“зан байдлыг таньж тогтоох”** гэж иргэний нисэхэд заналхийлэл учруулж болзошгүй этгээдийг биеийн хэл, дохио зангаа зэрэг зан байдлын хэвийн бус шинжээр таних аргаар илрүүлэхийг

ИНД-140

140.3 Тодорхойлолт

Аюулгүйн үзлэгийн цэг гэж аэродромын оператор ИНД-139.203(d)(4)-ийн дагуу, зорчигчийн аюулгүйн үзлэгт зориулан гаргасан талбайг;

Аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламж гэж тухайн цаг хугацаанд аюулгүйн хамгаалалт тогтоосон навигацийн байгууламжийг;

Аюулгүйн хамгаалалтын менежмент гэж 140.61(a)(5)-д заасан байрлал бүрийг хариуцсан нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтныг, үүнд тухайн ажилтны орлогч, болон тухайн ажилтан хариуцлагаа шилжүүлсэн бусад ажилтан багтана;

Зөвшөөрөгдөөгүй эд зүйл гэж хууль ёсоор эрх олгогдоогүй, эсхүл хүндэтгэх шалтгаангүй, эсхүл тухайн агаарын хөлгийн эзэмшигч, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөлгүй, эсхүл эдгээрээс тухайн зөвшөөрлийг олгох эрх олгогдсон этгээдийн зөвшөөрөлгүйгээр аливаа агаарын хөлгийн бүхээгт авч орсон, эсхүл авч орохыг завдсан дараах эд зүйлийг:

- 1) аливаа галт зэвсэг; эсхүл
- 2) аливаа бусад аюултай, эсхүл хор хөнөөл учруулах зэвсэг, эсхүл эдгээрийн
- 3) аливаа төрлийн хэрэгсэл; эсхүл
- 4) аливаа сум хэрэгсэл; эсхүл
- 5) аливаа тэсрэх бодис, эсхүл хэрэгсэл, эсхүл аливаа бусад гэмтэл учруулах
- 6) бодис, эсхүл агаарын хөлгийн, эсхүл агаарын хөлгийн бүхээгт байгаа
- 7) этгээдийн аюулгүй байдалд аюул учруулахад ашиглах аливаа төрлийн
- 8) хэрэгсэл;

Нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтан гэж Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн үндсэн ажилтан, эсхүл тухайн цаг хугацаанд нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтны үүрэг гүйцэтгэж буй этгээдийг;

Өндөр эрсдэлтэй нислэг гэж заналхийллийн ердийн хүчин зүйлээс илүү өндөр нөлөөнд өртөнө гэж дараах этгээдийн үнэлсэн нислэгийг:

- 1) Дарга; эсхүл
- 2) агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч; эсхүл
- 3) тухайн агаарын хөлгийг Бүртгэгч улс;
- 4)

Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн үзлэгийн цэг гэж аэродромын оператор 139.203(d)(4A)-ийн дагуу, аюулгүйн үзлэг болон шалгалт хийгдэх өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн цэгт аюулгүйн үзлэг болон шалгалт хийхэд зориулан гаргасан талбайг;

Энгийн нислэг гэж өндөр эрсдэлтэй нислэгээс бусад нислэгийг.

АХЕЗ

Нэр томьёо

"Иргэний нисэхийн үндэсний төв" гэж (цаашид "ИНҮТ" гэх) Монгол Улсын агаарын зай, нутаг дэвсгэрт агаарын навигацийн болон нисэх буудлуудын үйлчилгээг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид "ИНЕГ" гэх /-ын харьяа үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж,

"Аюулгүй байдал, хамгаалалтын алба" гэж (цаашид "АБХА" гэх) холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд аюулгүйн хамгаалалттай аэродром, навигацийн байгууламжийг иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах, иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий ИНЕГ-ын харьяа ИНҮТ-ийн салбар нэгж юм.

"Аюулгүйн үзлэг" гэж Хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай зүйлсийг илрүүлэхэд чиглэсэн техник болон бусад арга хэрэгсэл ашиглан хийх үзлэгийг;

"Аюулгүйн хамгаалалтын хяналт" гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, хориглосон болон сэжигтэй эд зүйлийг нисэх буудал, агаарын хөлөгт нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг;

"Агаарын хөлөг" гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах аливаа төхөөрөмжийг;

"Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа" гэж зорчигч, ачаа, шууданг агаарын хөлгөөр төлбөртэй тээвэрлэх үйл ажиллагааг;

"Аэродром" гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулж тусгайлан тоноглосон газар болон усан гадаргуу, түүн дээр байрлах барилга, байгууламж, тоноглол;

"Ачаа" гэж агаарын хөлөгт тээвэрлэх шуудан, эд зүйлс, тээшнээс бусад зүйлсийг;

"Анкет шалгах" гэж аюулгүй байдлын хяналтын ажилтныг ажилд авахад, эсхүл аюулгүй байдлын хяналтын ажилтныг дагалдуулахгүйгээр хориотой бүсэд нэвтрэх этгээдийн биеийн байцаалт, ажлын туршлага, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх зэргийг нягтлахыг;

"Аюултай бараа" гэж агаараар тээвэрлэх үед өөрийн шинж чанараараа иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин болон нислэгийн аюулгүй ажиллагаанд үлэмж хор хүргэж болох биет зүйл болон бодисыг;

"Ахлах ажилтан" гэж Иргэний нисэхийн хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахад аюулгүй байдал, хамгаалалтын албаны ээлжийн бие бүрэлдэхүүнийг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах ажилтныг,

"Аюулгүйн үзлэгийн ажилтан" гэж Аюулгүйн үзлэг шалгалтыг биечлэн гүйцэтгэх ажилтныг

“Аюулгүйн хамгаалалтын ажилтан ” гэж Нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх эрх бүхий хүн , тээврийн хэрэгслийн нэвтрэх үнэмлэхийг шалгаж , тээврийн хэрэгслийн аюулгүйн хамгаалалтын үзлэг хийн бүсэд нэвтрүүлэх ажилтныг ,

“Аюулгүйн хамгаалалттай бүс ” гэж Аюулгүй байдлын хяналт бүхий нисэх буудлын аэрадромын талбай , барилга байгууламж , түүний орчны хэсэг ,

“Аюулгүйн хамгаалалтын хяналтгүй бүс ” гэж ямар нэг зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй орж гарч болох нисэх буудлын барилга байгууламж , түүний орчны хэсэг

“Бүртгэл” гэж агаарын тээвэрлэгчийн тухайн нислэгээр үйлчлүүлэхээр мэдүүлэх үйл ажиллагааг;

“Бүртгэлийн цэг” гэж бүртгэл явуулах байршлыг;

“ Зохицуулагч ” гэж Нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай , аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалтын хяналтгүй бүсэд камерын хяналт тавих , перрон талбайн аюулгүйн хамгаалалтыг зохицуулж , хүн хүч , тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих ажилтныг ;

“ Зөвшөөрөгдөөгүй эд зүйл ” гэж агаарын хөлгөөр тээвэрлэхийг зөвшөөрөгдөөгүй эсхүл зөвхөн тээвэрлэлтийн тусгай журмын дагуу тээвэрлэх хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй эд зүйлсийг

“ Камерын хяналтын систем ” гэж хяналтын камерын дүрсийг тодорхой хүрээнд дамжуулан харах , бичих зориулалт бүхий төхөөрөмжүүдийн нэгдлийг;

“ Камерын бичлэг ” гэж зориулалтын төхөөрөмжинд хадгалагдсан хяналтын камерын дамжуулсан дүрсийг ;

“Нисэхийн аюулгүйн хамгаалалт” гэж иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогц арга хэмжээг;

“Нисэх баг” гэж нислэгийн хугацаанд агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангах хариуцлага хүлээсэн, хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэхтэй агаарын хөлгийн багийн гишүүдийг;

“Нисэхийн үйл ажиллагааны бүс” гэж нэвтрэх хяналт бүхий нисэх буудлын хөдөлгөөний талбай, түүнд холбогдох газар, барилга, барилгын зарим хэсэг;

“ Нэвтрэх үнэмлэх ” гэж нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хяналт бүхий өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын болон аюулгүйн хамгаалалтын бүсэд нэвтрэх зөвшөөрлийг үндэслэн олгосон бичиг баримт ;

“ Нэвтрэх хяналтын систем ” гэж нэвтрэх үнэмлэх уншигч тоног төхөөрөмж , программ хангамж

“ Нохой хөтлөгч ажилтан ” гэж Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаанд албаны нохойн давуу талыг ашиглах , сургах , тэжээх үүрэг гүйцэтгэх ажиллагааг биечлэн гүйцэтгэх ажилтныг ;

“Олон улсын нисэх буудал” гэж улсаас өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын нислэгийн агаарын хөлгийг хүлээн авах/явуулахаар тогтоосон, хилийн шалган нэвтрүүлэх боомт, цагаачлалын алба, гааль, амьтан, ургамлын хорио цээрийн хяналт бүхий нисэх буудлыг;

“Онцгой анхаарлын цэг” гэж гэмтсэн болон устгагдсаны улмаас иргэний нисэхийн үйл ажиллагаанд ноцтой саад учруулж болзошгүй нисэх буудлын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг;

“ Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс ” гэж Аюулгүйн үзлэгийн цэгээс агаарын хөлөг хүртэлх зорчигчдын танхим , тээш ялгах талбай , перрон , нислэгт бэлтгэгдсэн агаарын хөлөг , аюулгүйн үзлэг хийгдсэн тээш , ачаа , шуудан болон аюулгүйн хамгаалалттай бүсэд байрлах нислэгийн хоол хүнс бэлтгэх газар , цэвэрлэгээний талбай зэрэг илүү эрсдэлтэй гэж тодорхойлсон , нэвтрэх хяналт , бусад аюулгүйн байдлын хяналт илүү шаардлагатай хамгаалалттай бүсийн хэсэг;

“Пиротехникийн хэрэгсэл” гэж хурц гэрэл цацруулдаг буюу чанга дуу чимээ үүсгэдэг баяр ёслол, үзвэр, цэнгээний зориулалтаар ашиглагдах хэрэгслийг;

“Тэсэрч дэлбэрэх бодис” гэж тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг;

“Тэсэлгээний хэрэгсэл” гэж тэсэрч дэлбэрэх бодисын тэсрэлтийг үүсгэх зориулалттай цэнэг агуулсан өдөөгч хэрэгслийг;

“Тээш” гэж агаарын хөлөгт тээвэрлэгдэх нисэх багийн гишүүдийн, эсхүл зорчигчийн хувийн хэрэгцээний эд зүйлсийг;

“Үл дагалдах тээш” гэж тухайн тээшийг бүртгүүлсэн зорчигчоос тусад нь тээвэрлэхээр агаарын хөлөгт хүлээн авсан тээшийг;

“Цоожтой горим” гэж Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын болон аюулгүйн хамгаалагдсан бүсэд хүн ба тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах болон түр хугацаагаар хаах, нэвтрэх цэг, постууд болон нисэх буудлын гарц бүхий цэгүүдийн хаалга бүрийг эсхүл тусгайлан заасан хамгаалалтын цэгийн хаалгыг цоожлох ажиллагаа;

“Хорлон сүйтгэх үйл ажиллагаа” гэж улс төр, эсхүл гэмт хэргийн шалтгаанаар агаарын хөлөг, нисэх буудал болон агаарын навигацийн байгууламжид хор хөнөөл учруулах буюу устгах зорилготой ажиллагааг;

“Хөдөлгөөний талбай” гэж агаарын хөлөг хөөрөх, буулт үйлдэх, явгалах, маневр хийх талбай, перрон бүхий аэродромын хэсгийг;

“ Хилийн бүс ” гэж нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн хэсэг буюу явах зорчигчдын бүртгэл эхлэхээс агаарын хөлөг хөөрөх , ирэх чиглэлийн агаарын хөлөг буухаас хилийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалтын үйл ажиллагаа дуусах хүртэлх хугацаанд хилийн боомтод хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах зориулалтаар тусгайлан тоноглогдсон газрыг ;

“Эзэнгүй тээш” гэж тээшний зүүлттэй буюу зүүлтгүй, эзэн нь тогтоогдоогүй тээшийг;

“Эзэн нь тогтоогдоогүй тээш” гэж нисэх буудалд тээвэрлэгдэж ирсэн бөгөөд зорчигч өөрийн гэж мэдүүлээгүй тээшийг;

“Эрсдэлийн баг” гэж нисэх буудлын үйл ажиллагааны эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ боловсруулах багийг;

“Эрсдэл бүхий нисэх буудлын хэсэг” гэж нисэх буудлын хамгаалагдсан хашаа, шалган нэвтрүүлэх цэгүүд болон аэродромын аюулгүйн хамгаалагдсан бүсэд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахад өндөр шаардлага тавигдах цэг болон талбайг;

ЧХОУНБ-ЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХӨТӨЛБӨР

“Аэродром” агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулж тусгайлан тоногдсон газар болон усан гадаргууг;

“Аэродром эзэмшигч” Аэродромыг гэрчилгээжүүлэх, түүний аюулгүй байдал, хамгаалалт болон ашиглалтын үйл ажиллагааг зохицуулж буй ИНД-139 –ийн дагуу аэродромын Гэрчилгээ, эсхүл түр зөвшөөрөл олгогдсон этгээдийг;

Аэродромын үйл ажиллагааны бүс зурвас, аюулгүй байдлын талбай болон агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор аэродром дээр суурилуулсан аливаа газрын тоног төхөөрөмж, эсхүл байгууламжийг;

Аэродромын нислэгийн удирдлагын цамхаг аэродромын хөдөлгөөнд нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх байгууламжийг;

Аюултай бараа агаараар тээвэрлэх үед өөрийн шинж чанараараа иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин болон нислэгийн аюулгүй ажиллагаанд үлэмж хор хүргэж болох биет зүйл болон бодисыг;

Аюулгүй байдал хүний болон материаллаг нөөцийг хослуулах замаар иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах арга хэмжээг;

“аюулгүй байдлын үзлэг” хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон аюултай зүйлсийг илрүүлэхэд чиглэсэн техник болон бусад арга хэрэгсэл ашиглан хийх үзлэгийг;

Аюулгүйн хамгаалалттай бүс хамгаалагдсан бүсийн тодорхойлолттой нэгэн адил ойлгоно;

Бүртгэгдсэн тээш агаарын хөлгийн ачааны хэсэгт тээвэрлэгдэх зорчигчийн тээшийг;

Гар тээш зорчигч өөрөө хариуцан биедээ авч явахыг зөвшөөрсөн агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт тээвэрлэх тээшийг;

Дагалдах тээш тухайн тээшийг бүртгүүлсэн зорчигчийн хамт тээвэрлэхээр агаарын хөлөгт хүлээн авсан тээшийг;

Концессын гэрээ Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Үндэсний хөгжлийн газар болон НУБИЭ ХХК нарын хооронд байгуулсан “Улаанбаатар хотын олон нисэх онгоцны шинэ буудлын менежмент”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээг;

Маневрын талбай агаарын хөлгийн хөөрч буух зурвас, явгалах замыг;

Нисэх буудлын аюулгүй байдлын хороо иргэний нисэхийн болон нисэх буудлын аюулгүй байдлыг хариуцсан албан тушаалтанд зөвлөгөө өгөх хороог;

Нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөр хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор ИНАБЖ-ын шаардлагад нийцүүлэн боловсруулж, нисэх буудалд хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон баримт бичгийг;

Нисэх буудлын үйл ажиллагааны бүс "Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент"-ийг хэрэгжүүлэх концессын гэрээнд тусгасан Нисэх буудлын талбайг;

Нисэх буудлын харуул хамгаалалт хариуцсан байгууллага нисэх буудлын аюулгүй байдлын бүсүүдэд санамсаргүй зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэх, зөвшөөрөлгүй үйлдлийг зогсоох үүрэг бүхий харуул хамгаалалтын байгууллага;

Нэвтрэх үнэмлэх нисэх буудлын бүсүүдэд нэвтрэх эрх олгосон баримт бичгийг;

Олон улсын нисэх буудал гааль, иргэн харьяат, эрүүл ахуй, хорио цээрийн хяналт болон бусад ижил төстэй албан үүргийг хэрэгжүүлдэг, олон улсын нислэг хүлээн авах болон нислэгт гаргахаар тогтоосон нисэх буудлыг;

Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс хориотой бүсийн тодорхойлолттой нэгэн адил ойлгоно;

Хамгаалагдсан бүс аюулгүй байдлын хяналт бүхий нисэх буудлын аэродромын талбай, барилга байгууламж, түүний орчны хэсгийг;

Хориотой бүс аюулгүй байдлын үзлэгийн цэгээс агаарын хөлөг хүртэлх зорчигчдын танхим, тээш ялгах талбай, перрон, нислэгт бэлтгэгдсэн агаарын хөлөг, аюулгүй байдлын үзлэг хийгдсэн тээш, ачаа, шуудан болон хамгаалагдсан бүсэд байрлах нислэгийн хоол хүнс бэлтгэх газар, цэвэрлэгээний талбай зэрэг илүү эрсдэлтэй гэж тодорхойлогдсон нэмэлт хяналт, бусад аюулгүй байдлын хяналт илүү шаардлагатай хамгаалагдсан бүсийн хэсгийг;

Сэжигтэй эд зүйлс эзэнгүй, эсхүл эзнийг нь тогтоох боломжгүй аюул заналхийлэл агуулсан байж болзошгүй эд зүйлсийг;

Төрийн тусгай хамгаалалтын бүс гадуур хамгаалалт зохиож байгаа болон төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд хамаарах тодорхой орчин, нутаг дэвсгэрийг;

Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг;

Тэсэрч дэлбэрэх бодисоор заналхийлэх нислэг үйлдэж буй, эсхүл газарт байгаа агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа, нисэх буудал, иргэний нисэхийн байгууламж болон хувь хүнд тэсэрч дэлбэрэх бодис, хэрэгслийн аюул учирч болзошгүй талаар эзэнтэй, эсхүл эзэнгүй, үнэн, эсхүл худал мэдээллээр заналхийлэхийг;

Үзлэгийн дараах бүс аюулгүй байдлын үзлэгийн цэг болон агаарын хөлгийн хоорондох хэсгийг;

Үл дагалдах тээш

- газрын үйлчилгээний ажилтны санамсар болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалан өөр агаарын хөлөгт ачигдсан тээш;
- цаг агаарын нөхцөл байдал болон бусад шалтгааны улмаас өөр нислэгт шилжүүлсэн зорчигчийн тээш;
- зорчигч агаарын хөлөгт суугаагүй эсхүл хөөрөхөөс өмнө агаарын хөлгөөс буусан;
- төлөвлөж байснаасаа өмнө явсан зорчигчийн тээш;
- тээшний дамжуурга болон бүртгэлийн системийн гэмтлээс шалтгаалан төлөвлөсөн нислэгээс хоцорсон тээш;

Хилийн хяналт агаарын тээврээр зорчиж буй этгээдийг тухайн улсын нутаг дэвсгэрт орох, дамжин өнгөрөх, гарахад хяналт тавихаар тухайн улсаас тогтоосон арга хэмжээг;

Хилийн хяналт, шалгалтын байгууллага улсын хил нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт явуулах, бүртгэх эрх бүхий улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагыг;

Хориглосон эд зүйлс агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон эсхүл зөвхөн тусгай журмын дагуу тээвэрлэх хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй эд зүйлсийг;

Хөдөлгөөний талбай агаарын хөлгийн хөөрөлт болон буулт, мөн газар дээр хөдөлгөөн хийхэд зориулагдсан, маневрын талбай, техник үйлчилгээний талбай болон апроныг багтаасан аэродромын тодорхой хэсгийг;

Хяналтын камер хянах зориулалтаар ашигладаг, аналог болон тоон сүлжээнд холбогдсон, системийн хувьд эцсийн цэгт байрлах дүрс бичих биет төхөөрөмжийг;

Эзэн нь тогтоогдоогүй тээш нисэх буудалд тээвэрлэгдэж ирсэн, зорчигч өөрийн гэж мэдүүлээгүй тээшийг

Эзэнгүй тээш тээшний зүүлттэй буюу зүүлтгүй, эзэн нь тогтоогдоогүй тээшийг;

Эмзэг байдлын үнэлгээ онцгой анхаарлын цэгүүдэд хийх эрсдэлийн үнэлгээг;

Эрсдэлийн баг нисэх буудалд иргэний нисэхийн эсрэг учирч болзошгүй аюул, заналхийлэл нэмэгдэхэд ирсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээг төлөвлөх багийг;

Хөндлөнгийн хууль бус үйлдэл иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлөх дараах үйлдэл болон оролдлогыг:

1. агаарын хөлгийг хууль бусаар булаан эзлэх;
2. үйлчилгээнд гарсан агаарын хөлгийг устгах;
3. агаарын хөлөгт болон нисэх буудалд хүн барьцаалах;
4. агаарын хөлөг, нисэх буудлын хамгаалагдсан бүс болон агаарын навигацийн тоног төхөөрөмж, байгууламжид хүч түрэмгийлэн нэвтрэх;
5. гэмт хэрэг үйлдэх зорилгоор агаарын хөлгийн бүхээг, нисэх буудалд зэвсэг эсхүл аюултай хэрэгсэл болон эд зүйлсийг нэвтрүүлэх;
6. үйлчилгээнд гарсан агаарын хөлгийг хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах буюу үхэлд хүргэх эсхүл эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд ноцтой хохирол учруулах зорилгоор ашиглах;
7. нислэг үйлдэж буй эсхүл газарт байгаа агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа, нисэх буудал, түүний барилга байгууламж дахь зорчигч, нисэх багийн гишүүд, газрын үйлчилгээний ажилтан болон иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хуурамч мэдээ, мэдээллийг тараах;

Онцгой байдлын

төлөвлөгөө

Код1- Нисэх буудалд тохиолдсон агаарын хөлгийн осол, зөрчил

Код2- Нисэх буудлын гадна тохиолдсон агаарын хөлгийн осол, зөрчил

Код3- Онцгой байдлын үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны бэлэн байдлыг шаардах нислэг техникийн осол, зөрчил

Код4- Барилга байгууламжид гарсан гал түймэр

Код5- Шатахуун асгаралт, аюултай ачааны осол, зөрчил

Код6- Агаарын хөлгийг тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслээр заналхийлэх үйлдэл

Код7- Барилга байгууламжийг тэсрэх хэрэгслээр заналхийлэх үйлдэл

Код8- Агаарын хөлгийг булаан эзлэх үйлдэл

Код9- Нисэх буудалд эрүүл мэндийн асуудалтай холбоотой үүссэн онцгой байдал

Код10- Нисэх буудалд тохиолдсон байгалийн гамшиг

Авран туслах гэж аюул тулгарсан , эсхүл аюулд нэрвэгдсэн агаарын хөлөгт явсан хүмүүсийг аврах , тэдэнд эмнэлгийн анхны болон бусад шаардлагатай тусламж үзүүлэх , аюулгүй газар нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг

Аврах баг гэж эрэн хайх ,авран туслах үйл ажиллагааг түргэн шуурхай явуулах шаардлагатай тоног төхөөрөмж бүхий мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн нэгжийг

Агаарын хөлгийг барьцаалах гэж нэг буюу бүлэг этгээд агаарын хөлгийг агаарт эсхүл газарт булаан авах хууль бус үйлдлийг

Агаарын хөлөг ашиглагч гэж агаарын хөлөг ашиглан үйл ажиллагаа эрхэлж байгаа болон эрхлэхээр санал болгож буй иргэн, аж ахуйн нэгж , байгууллага

Ангилах гэж бэртэж гэмтэгсдийг тэдний гэмтлийн төрөл хэмжээгээр ялгахыг (нэрвэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэхийн тулд дараах төрлөөр буюу I - маш яаралтай II - яаралтай III- онц бэртэлгүй,бэртэлгүй IV- нас барагсад гэж ангилан хаяг зүүх аргаар ялгах)

Ангилах талбай - гэж ангилах үйл ажиллагаа явагдах газар

Ангилах хаяг- гэж өвчтөнийг гэмтлийн зэрэг төрлөөр нь ангилан тэмдэглэсэн зүүлтийг

Аюул тулгарсан агаарын хөлөг гэж агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, түүнийг нисэх баг өөрийн үйл ажиллагаагаар арилгаж чадахгүйд хүрсэн , эсхүл агаарын хөлөг холбоогүй буюу байрлал нь тодорхой бус болсныг

Аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг гэж явгалалт , хөөрөлт , буулт, нислэгийн үед гэмтэж аргагүйдсэн буулт үйлдсэн,эсхүл бүрэн эвдэрснийг

Аюултай ачаа гэж агаараар тээвэрлэх үед өөрийн шинж чанараараа иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин болон нислэгийн аюулгүй ажиллагаанд үлэмж хор хүргэж болох биет зүйл болон бодисыг

Аюулын мэдээлэл гэж аюул тулгарсан , эсхүл аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийн талаар эрэн хайх ,авран туслах үйл ажиллагааг гүйцэтгэх , түүнд оролцох байгууллага , нэгжид мэдээлэх агаарын навигацийн үйлчилгээг

Газрын үйлчилгээний байгууллага гэж агаарын тээвэрлэгч нарт газрын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагыг

Галын ахлах удирдагч гэж гал унтраах үйл ажиллагааг удирдах Аврах туслах гал унтраах албанаас томилогдсон хүнийг

Гадаад хамгаалалтын бүс гэж онцгой байдлын бүсийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор дотоод хамгаалалтын бүсийн гадуурх талбайг

Дотоод хамгаалалтын бүс гэж онцгой байдлын үед зааварлах , зохицуулах , хянах , холбоо тогтоох зэрэг үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хамгаалалтанд авсан талбайг

Зөрчил гэж осол болон ноцтой зөрчлөөс бусад агаарын хөлгийн ашиглалттай холбогдсон , агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагаанд нөлөөлж байгаа эсхүл нөлөөлж болзошгүй тохиолдол/ үйл явдлыг

Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагаанй бүс гэж хил хязгаарт нь ЭХАТ үйлчилгээ явагдаж байгаа , авран хамгаалах зохицуулах төвтэй холбоотой тодорхой хэмжээний бүсийг

Нислэгийн үе дэх онцгой байдал гэж зорчигчдын болон агаарын хөлгийн үйл ажиллагааны хэвийн байдалд нөлөөлөх нислэгийн үед гарсан онцгой байдлыг

Нислэгийн хөдөлгөөн удирдах цамхаг гэж нисэх буудлын бүсэд нислэгийн хөдөлгөөн удирдан хянах үйлчилгээ явуулах зорилготой байгууламжийг

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ гэж нислэгийн мэдээллийн , аюул түгшүүрийн мэдээллийн , нислэгийн хөдөлгөөний зөвлөмжийн болон нислэгийн хөдөлгөөний удирдлага /бүсийн ойртолтын , аэродромын удирдлагын үйлчилгээ /- ын үйлчилгээг багтаасан нийтлэг ойлголтыг

Нисэх буудлын захирал гэж Чингис хаан ОУНБ-ын удирдлагын болон аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг удирдах хариуцлага хүлээсэн хувь хүнийг

Нисэх буудлын хамгаалагдсан бүс гэж аюулгүй байдлын хяналт бүхий нисэх буудлын аэродромын талбай, барилга байгууламж, түүний орчны хэсгийг

Нисэх буудлын хязгаар гэж Нисэх буудлынүйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа , ИНЕГ-ын эзэмшлийн газрыг

Онц ноцтой байдал дахь сэтгэлийн хямрал гэж ажилчид өөрийн хүлээсэн үүргийг бүрэн гүйцэтгэхэд сөрөг хүчтэй нөлөө үзүүлэх , ажилчдыг сэтгэлийн хямралд оруулж буй хэвийн бус байдлыг

Онцгой байдлыг зохицуулах штаб гэж Онцгой байдлын үед хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах өргөтгөсөн штаб

Онцгой байдлын бүрэн хэмжээний дасгал сургуулилт гэж Онцгой байдлын үед ашиглагдах бүх нөөцүүдийг хамарсан сургуулилтыг

Онцгой байдлын дасгал, сургуулилт гэж Онцгой байдалд ажиллах төлөвлөгөөний ашиглалтыг сайжруулах зорилгоор төлөвлөгөөг шалгах , төлөвлөлтийн дагуу гүйцэтгэгдэх үйл явдлыг

Танхимын тактикийн сургуулилт гэж Онцгой байдлын үед ашиглах нөөцийн чадал , нэгдмэл байдлыг шалгах хамгийн энгийн зардал багатай дасгалыг

Хэсэгчилсэн дасгал гэж нэг буюу хэд хэдэн оролцогчидтойгоор энэхүү журмын дагуу хийгдэх дасгалыг

Онцгой байдлын төлөвлөгөө гэж Нисэх буудлын хязгаар болон түүний ойр орчимд тохиолдож болох онцгой байдлын өмнө, онцгой байдлын үед болон түүнийг цуцалсны дараа холбогдох алба , байгууллагуудын гүйцэтгэх үйлдэл , үйл ажиллагааг жагсаасан баримтыг

Онцгой байдлын үе гэж Тодорхой бус, сэрэмжлүүлсэн, аюултай нөхцөл байдлын аль ч үеийг илэрхийлэх ерөнхий ойлголт

Ослын түгшүүр гэж онцгой нөхцөл байдлыг холбогдох алба байгууллагуудад зарлах системийг

Ослын үе гэж агаарын хөлөг болон түүнд яваа хүмүүст аюул тулгарсан ба яаралтай тусламж шаардлагатай болсон үе /**DETRESFA**- ослын үе шатыг илэрхийлэхэд ашиглах түлхүүр үг/

Осол гэж аливаа этгээд нислэг үйлдэх болон зорчих зорилгоор агаарын хөлгийн бүхээгт орсон үеэс эхлэн , агаарын хөлөгт байгаа бүх этгээд хөлгийн бүхээгийг бүрэн орхих хүртэлх хугацаанд:

- а) хэн нэгэн этгээд дараах нөхцөлд хүнд гэмтэл авах буюу амь насаа алдах*
 - тухайн агаарын хөлөгт байх үедээ , эсхүл агаарын хөлөгтэй шууд буюу агаарын хөлгөөс салсан хэсэгтэй харьцсаны улмаас , эсхүл сэнс болон тийрэлтэт хөдөлгүүрийн хийн урсгалын шуул нөлөөлөлд орсны улмаас
- б) агаарын хөлөг гэмтэх буюу түүний хийцэд эвдрэл гарсны улмаас*
 - агаарын хөлгийн үндсэн хийцийн бат бөх чанар болон нислэг, техникийн үзүүлэлтүүд алдагдах, ба гэмтсэн хэсгийг солих , эсхүл томоохон хэмжээний засвар шаардагдах
- в) агаарын хөлөг сураггүй алга болох, эсхүл түүнд хүрэх боломжгүй газарт байхыг тус тус хэлнэ.*

Сувилах талбай гэж нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх газар/талбайг

Талбарын захирагч гэж Онцгой байдлын үед үйл ажиллагааг онцгой байдлын талбарт зохицуулах үүрэгтэй , энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан хариуцлагатай ахлах ажилтныг

Тодорхой бус үе гэж агаарын хөлөг болон түүнд яваа хүмүүсийн аюулгүй байдлын талаар эргэлзээ төрүүлсэн нөхцөл байдал бий болсон үеийг

Торлосон зураг гэж тухайн бүсийн аливаа цэгт хүрэх үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор тухайн бүсийн газрын зургийг торлож , үсэг тоогоор тэмдэглэсэн зургийг

Тусгаарлах гэж өвчтэй буюу халдвар авсан хүн , халдварт өртсөн гар тээш , ачаа шууданг халдвар буюу бохидолт тархахаас сэргийлэх зорилгоор бусдаас ялгаж байрлуулахыг

Тусгаарлах талбай гэж тэсрэх бөмбөгөөр заналхийлсэн, агаарын хөлгийг булаан авсан, эсхүл аюултай ачаа , халдварт өвчинтэй холбогдон гарсан Онцгой байдлын үед уг агаарын хөлгийг байрлуулахаар төлөвлөгөөнд тусгасан аэродромын хэсгийг

Түгшүүрийн үе гэж агаарын хөлөг болон түүнд яваа хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулж болохуйц хүчин зүйлүүд бий болсон үеийг

Тэсрэх бөмбөгөөр заналхийлэх гэж энэ нь 2 хэсэгт хуваагддаг:

- ❖ **ӨВӨРМӨЦ ЗАНАЛХИЙЛЭЛ**– тэсрэх хэрэгслэлийн талаар ямар нэгэн тодорхой мэдээлэлтэй байх , жишээ нь идэвхижих цаг, байрлал, тэсрэх хэрэгслэлийн төрөл эсхүл бүр детальчилсан мэдээлэл
- ❖ **ЕРДИЙН ЗАНАЛХИЙЛЭЛ**- тэсрэх хэрэгсэл тавигч этгээд эсвэл түүний хамсаатан зөвхөн агаарын хөлөгт , нисэх буудлын барилга байгууламжид эсвэл түүний эзэмшил газарт тэсрэх хэрэгсэл тавьсныг мэдэгдэх

Удирдлагын хөдөлгөөнт штаб гэж Онцгой байдлын талбарын захирагч байрлаж зааварчилгаа, зохицуулалт , хяналт холбоо тогтоох үйл ажиллагааг төвлөрүүлэн гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд байрлан ажиллаж буй штабыг

Урьдаас товлосон зорчигчдыг байрлуулах газар гэж бага бэртэлтэй болон бэртэлгүй зорчигчдыг хүлээлгэх газрыг

Цуглуулах талбай гэж хүнд бэртсэн хүмүүсийг эхэлж цуглуулах газрыг

Уулзах цэг гэж Онцгой байдлын үед үйл ажиллагаагаа бүх ажилчид болон автомашинууд цугларах урьдаас товлосон цэгийг. Уулзах цэгээс цугларах бүс рүү / эсвэл онцгой байдлын талбар руу очих зааварчилгааг авна

Цугларах бүс гэж Онцгой байдлын үед ажиллах хүмүүс болон техник хэрэгслэлүүдийг ажлын бэлэн байдалд төвлөрүүлж байрлуулахаар гадаад хамгаалалтын бүсэд байрлах талбайг

Халдварын сэжигтэй гэж хүн амын эрүүл мэндэд аюул занал учруулж болох эрсдэлд өртсөн буюу өртсөн байх магадлалтай өвчин тараах эх үүсвэр байж болзошгүй хүмүүс, гар тээш , ачаа шууданг

Хамтран ажиллах баталгаа гэж байгууллагууд онцгой байдлын үед хамтран ажиллах тухай гаргасан баталгааг

Хориотой бүс гэж зохих зөвшөөрөлгүй хүн , тээврийн хэрэгсэл орохыг хориглосон бүсийг

Хөдөлгөөний талбай гэж агаарын хөлгийн хөөрөх , буух, явгалах зурвасууд , маневэр хийх талбай болон перроноос бүрдсэн аэродромын хэсгийг

Шинжлэн судалгаа гэж гарч болзошгүй нислэг техникийн хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах , дүгнэлт хийх , түүнчлэн гарсан хэргийн шалтгааныг тогтоон аюулгүй байдлын зөвлөмж бэлтгэх үйл ажиллагааг

Шүүх магадлан шинжлэлийн эмч гэж иргэдийн үхлийн шалтгааныг судалж , тодорхойлох үүрэг бүхий ажилтныг

Эмнэлгийн тусламж гэж гэмтэж бэртсэн зорчигчдыг ангилах, анхны тусламж үзүүлэх, тэдний биеийн байдлыг тогтворжуулах, зохих эмнэлгүүд рүү тээвэрлэх үйл ажиллагааг

Эмнэлгийн тээвэрлэх талбай гэж онцгой байдалд нэрвэгдэгсдийг цаашид эмнэлгийн байгууллагууд руу тээвэрлэх зорилгоор цуглуулах талбайг

Эрэн хайх гэж Аюул тулгарсан эсвэл аюулд өртсөн агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох зорилгоор бие бүрэлдэхүүн, төрөл бүрийн тээврийн хэрэгсэл оролцсон , эрэн хайх үйл ажиллагааг

Эрэн хайх, авран туслах мэдээлэл зохицуулах төв гэж өөрийн хариуцсан бүсэд эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл зохицуулах үүрэг бүхий нэгжийг

Эрэн хайх, авран туслах үйлчилгээний салбар гэж эрэн хайх, авран туслах ажиллагааг зохицуулах төв, түүний салбрууд эсвэл шуурхай эргүүл гэх мэт тухайн нөхцөл байдлаас хамааран нэрлэх ерөнхий нэр томъёо

ЧХОУНБ-Онцгой нөхцөлийн төлөвлөгөө

1.1.3 . ТОДОРХОЙЛОЛТ

1. Энэхүү төлөвлөгөөнд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно . Үүнд:

Аврах , гал унтраах Хүний амийг ослоос аврах , эд хөрөнгийг хамгаалах , галын аюул , хор хохирлыг багасгах арга хэмжээ

Агаарын хөлгийн осол Нислэг үйлдэж буй болон нислэг үйлдэхээр бэлтгэгдэж буй агаарын хөлөг гэмтсэн , түүний хийцэд их хэмжээний эвдрэл гарсан , сураггүй алга болсон болон тэдгээрийн улмаас хүний амь нас хохирсон , хүнд гэмтэл учирсан тохиолдол

Агаарын хөлгийг булаан эзлэх Тодорхой үйлдэл хийлгэх , албадах зорилгоор агаарын хөлгийг газарт болон агаарт хүч түрэмгийлэн булаан авах үйлдэл

Агаарын хөлөг ашиглагч Агаарын хөлөг ашиглан үйл ажиллагаа эрхэлж байгаа болон эрхлэхэр санал болгож буй иргэн , аж ахуйн нэгж , байгууллага

Анхны тусламж Осол зөрчлийн үед эмнэлгийн тусламж иртэл нисэх буудлын анхны тусламжийн эд зүйлсийг ашиглан нэрвэгдэгсдэд уруулах яаралтай тусламж

Ахлах гал сөнөөгч Гал түймэр гарсан анхны дуудлагаар гал унтраах нэгжийг удирдамж ирсэн, унтраах ажлыг газар дээр нь удирдан зохион байгуулах авран туслах гал унтраах албанаас томилогдсон хүнийг

Аэродромын удирдлагын цамхаг Аэродромын хөдөлгөөнийг зохицуулах нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээний цамхаг

Аюултай бараа Техникийн зааварчилгааны аюултай ачааны жагсаалтад орж ангилагдсан иргэдийн эрүүл мэнд , эд хөрөнгө , хүрээлэн буй орчин болон нислэгийн аюулгүй ажиллагаанд үлэмж хор хүргэх эрсдэл бүхий биет зүйл болон бодис

Баг Нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын ажилтнуудын үйл ажиллагааны чиглэлээр нь бүлэг болгон хувааж , онцгой нөхцөл тохиолдсон үед анхан шатны авч хэрэгжүүлэх арга хэмжээнд сургаж , дадлагажуулсан орон тооны бус баг

Байгалийн гамшиг Байгаль болон хүний бүтээн байгуулалтыг эвдэн сүйтгэх байгалийн аюултай үзэгдэлүүд

Газрын үйлчилгээний байгууллага Агаарын тээвэрлэгч нарт газрын үйлчилгээ үзүүлж буй байгууллага

Гамшиг Аюулт үзэгдэл , ослын улмаас олон хүний амь нас , эрүүл мэнд хохирох , мал , амьтан олноор хорогдох , эд хөрөнгө , түүх , соёлын дурсгалт зүйл хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг , нийгмийн дотоод нөөц , боломжоос давсан хохирол учрахыг

Зөрчил Осол болон ноцтой зөрчлөөс бусад агаарын хөлгийн ашиглалттай холбогдсон агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагаанд нөлөөлж байгаа эсхүл нөлөөлж болзошгүй тохиолдол

Нислэг Агаараас хүнд агаарын хөлгийн хувьд хөөрөх зорилгоор зогсоолоос Модлохоос эхлэн газарт эргэн бууж хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх Агаараас хөнгөн агаарын хөлгийн хувьд газрын гадаргуугаас хөөрөхөөс эхлэн газардах хүртэлх үйл ажиллагаа

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ Нислэгийн мэдээллийн аюул түгшүүрийн мэдээллийн нислэгийн хөдөлгөөний зөвлөмжийн болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээг багтаасан нийтлэг ойлголт

Нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөгөө Нисэх буудалд тохиогдож болзошгүй онцгой нөхцөлийн үед ажиллах байгууллагуудын авах арга хэмжээ , үйл ажиллагааг заасан баримт

Онцгой нөхцөл Нисэх буудалд агаарын хөлөг осолдсон , агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагаанд нөлөөлж байгаа , эсхүл нөлөөлж болзошгүй тохиолдол бий болсон , хөндлөнгийн хууль бус үйлдэлд хүний амь нас , эд хөрөнгө ертөн , эмх замбараагүй байдал үүссэн , барилга байгууламжид гал гарсан , гал гарах нөхцөл бүрдсэн халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн , байгалийн гамшиг тохиолдсон үе

Онцгой нөхцөлийн дасгал , сургуулилт Онцгой нөхцөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах болон нисэх буудалд тохиолдож болзошгүй онцгой нөхцөлийн үед ажиллах ажилтнуудад дадал олгох зорилгоор зохион байгуулж буй сургалт

Онцгой нөхцөлийг зохицуулах штаб Онцгой нөхцөл үүссэн үед хүний амь насыг аврах, эд хөрөнгө хамгаалах , эвдрэл гэмтлийг багасгах , хохирол хор уршгийг арилгах,хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаануудыг удирдан зохион байгуулах , шийдвэр гаргах өргөтгөсөн бүлэг

Осол Үйлдвэрлэл , технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж , барилга байгууламж ноцтой эвдрэх , нурах , тээврийн хэрэгсэл осолдох , сүйрэх , цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах , дэлбэрэлт болох зэргийг

Талбарын захирагч Онцгой нөхцөлийн үед үйл ажиллагааг онцгой нөхцөлийн талбарт зохицуулах үүрэгтэй , энэхүү төлөвлөгөөний дагуу томилогдсон хариуцлагатай ахлах ажилтан

Торлосон зураг Тухайн бүсийн газрын зургийг босоо ба хэвтээ шулуунуудаар адил хэмжээтэй дөрвөлжингүүдэд хувааж , торлон , координатын систем үүсгэн дөрвөлжин тус бүрийг үсэг , тоогоор тэмдэглэсэн зураг

Тусгаарлах талбай Хөндлөнгийн хууль бус үйлдэл , аюултай ачаа болон халдварт өвчний тархалтын аюулд өртсөн агаарын хөлгийг байрлуулах аэродромын хэсэг

Тусгаарлах Өвчтэй буюу халдвар авсан хүн , халдварт өртсөн гар тээш , ачаа , шууданг халдвар буюу бохирдолт тархахаас сэргийлэх зорилгоор бусдаас ялгаж байрлуулах

Тэсрэх бөмбөгөөр заналхийлэх Нислэг үйлдэж байгаа , эсхүл газарт байгаа агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа болон нисэх буудал , иргэний нисэхийн байгууламж , хувь хүнд тэсэрч дэлбэрэх бодис , тэсэлгээний хэрэгслийн аюул учирч болзошгүй талаар эзэнтэй , эсхүл эзэнгүй , үнэн , эсхүл худал мэдээллээр заналхийлэх

Удирдлагын хөдөлгөөнт штаб Онцгой нөхцөлийн талбараас хүний амь насыг аврах , эд хөрөнгө хамгаалах , эвдрэл гэмтлийг багасгах , хохирол , хор уршгийг багасгах арга хэмжээг гардан зохион байгуулах , талбар дээрх хүн хүч , техник хэрэгслийг хуваарилах хөдөлгөөнт бүлэг . УХШ - ыг талбарын захирагч удирдана .

Уулзах цэг Онцгой нөхцөлийн үед хамтран ажиллах , туслалцаа үзүүлэх байгууллагын хун хүч тээврийн хэрэгсэл цугларах урьдаас товлосон цэг

Халдварын сэжигтэй ОУЭМД - ээр зохицуулагддаг халдварт өвчний сэжигтэй хүн, халдварт өвчний сэжигтэй мал , амьтан

Хамтран ажиллах гэрээ онцгой нөхцөл үүссэн үед байгууллагуудтай байгуулсан гэрээ хамтран ажиллах гэрээ

Хөдөлгөөнт бүс Перрон болон маневрийн талбайг багтаасан агаарын хөлгийн Хөөрөлт буулт , Явгалалтад зориулагдсан аэродромын тодорхой хэсэг

Цугларах бүс Нисэх буудал дээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагын ажилчид болон шаардлагатай техник хэрэгслийг ажлын бэлэн байдалд төвлөрүүлж байрлуулах цэг

Шинжлэн шалгах Осол , зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах , дүн шинжилгээ хийх , шалтгааныг тогтоох , дүгнэлт бэлтгэх , хэрэв шаардлагатай бол аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргах зэрэг үйл ажиллагаа

Эрэн хайх авран туслах үйлчилгээ Эрэн хайх , авран туслах ажиллагааг зохицуулах төв , түүний салбарууд эсхүл шуурхай эргүүл гэх мэт тухайн нөхцөл байдлаас хамааран нэрлэх ерөнхий нэр томъёо

Эмнэлэг рүү тээвэрлэх талбай Онцгой нөхцөлд нэрвэгдэгсдийг цаашид эмнэлгийн байгууллагууд руу тээвэрлэх зорилгоор цуглуулах талбай

Ээлжийн менежер Duty manager Нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ээлжийн хугацаанд удирдан зохион байгуулах , шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан

Эрэмбэлэн ангилах Осолд нэрвэгдэгсдийг амь насанд халтай үзүүлэлтээр нь ангилахыг

/ I-Маш яаралтай , II - яаралтай ,

III - яаралтай тусламж шаардлагагүй , IX - нас барагсад)

Эрэмбэлэн ангиллын талбай Эрэмбэлэн ангилах үйл ажиллагаа явагдах газар

Эрэмбэлэн ангиллын зүүлт Нэрвэгдэгсдийг бэртлийн зэрэг болон амь насанд халтай үзүүлэлтээр нь ангилан тэмдэглэсэн зүүлт

Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журам

Зорилго

Иргэний нисэхийн эсрэг болзошгүй заналхийллийн үед Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл болон тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах байгууллага, онцгой байдал, иргэний нисэхийн зэрэг төрийн байгууллагуудаас хэрэгжүүлэх арга хэмжээний харилцан ажиллагааг нэгтгэн зохицуулахад энэхүү журмын мөрдлөг оршино.

Иргэний нисэхийн эсрэг заналхийлэл гэж нислэг үйлдэж буй болон газарт байгаа агаарын хөлөг, нисэх буудал, иргэний нисэхийн навигацийн тоног төхөөрөмж, барилга байгууламж, зорчигч, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, иргэний нисэхийн аюулгүй байдалд хор хохирол учруулах, нисэхийн аюулгүй ажиллагааг алдагдуулж болзошгүй тухай бодит мэдээлэл бүхий хөндлөнгийн хууль бус үйлдэл гарч болох эрсдэлтэй нөхцөл байдлыг

Заналхийллийн түвшин гэж аливаа шугамаар авсан заналхийллийн талаарх мэдээллийг боловсруулж, үнэлсний дараа үндэсний болон нисэх буудлын түвшинд хүний хүчин зүйл, материаллаг нөөцийг ашиглах замаар сэжиг бүхий төхөөрмж болон эд зүйлсийг олж илрүүлэх, аюулыг саармагжуулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зэрэг иж бүрэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд эрх бүхий байгууллагаас зарлах нөхцөл байдлын хэм хэмжээг

Болзошгүй нөхцөл байдал хөндлөнгийн хууль бус үйлдэл үйлдэгдэх магадлалтай байгаа талаар мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагад тодорхой мэдээлэл байгаа болон бодитой аюул заналхийлэл үүссэн үеийг